



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2021 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/107

Улаанбаатар хот

Журам батлах тухай


Батлан хамгаалахын сайдын 2020 оны А/77 тушаалаар батлагдсан "Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн дүрэм"-ийн 11.7.1, 6.6, Эрдмийн зөвлөлийн хуралдааны 2021 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дөрөвдүгээр тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. "ҮБХИС-ийн "Судалгааны ёс зүйн хяналтын хороо"-г нэгдүгээр, "Судалгааны ёс зүйн хяналтын хорооны ажиллах журам"-ыг хоёрдугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.
2. Журмыг 2021 оны 6 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн мөрдлөг болгож ажиллахыг ҮБХИС-ийн Судалгааны ёс зүйн хяналтын хорооны дарга (хурандаа Б.Өлзийхуяг)-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит чанарын үнэлгээний алба (хошууч С.Эрдэнэчимэг)-нд даалгасугай.

ЗАХИРАЛ
БРИГАДЫН ГЕНЕРАЛ




П.ЖАРГАЛАН



СУДАЛГААНЫ ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН ХОРОО

1. Судалгааны ёс зүйн хяналтын хорооны дарга:
Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа хариуцсан захирал
2. Судалгааны ёс зүйн хяналтын хорооны нарийн бичгийн дарга:
Эрдэм шинжилгээ, инновацын хэлтэсийн дарга
3. Судалгааны ёс зүйн хяналтын хорооны гишүүд:
 - 3.1. Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга;
 - 3.2. Ахисан түвшний сургалтын албаны дарга;
 - 3.3. БХУА-ийн эрдэм шинжилгээ, сургалтын албаны дарга;
 - 3.4. ЦНДС-ийн эрдэм шинжилгээ, сургалтын албаны дарга;
 - 3.5. АБДС-ийн эрдэм шинжилгээ, сургалтын албаны дарга;
 - 3.6. ЦХПК-ийн эрдэм шинжилгээ, сургалтын албаны дарга;
 - 3.7. БХМСҮТ-ийн эрдэм шинжилгээ, сургалтын албаны дарга;
 - 3.8. Багшийн хөгжлийн төвийн дарга;
 - 3.9. Гадаад хэл сургалтын төвийн дарга.



**ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН
СУДАЛГААНЫ ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН ХОРООНЫ АЖИЛЛАХ ЖУРАМ**
Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмаар Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн (цаашид ҮБХИС гэх) Судалгааны ёс зүйн хяналтын хорооны (цаашид СЕЗХХ гэх) бүтэц зохион байгуулалт, бүрэлдэхүүн, үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2. Судалгааны ёс зүйн хяналтын хорооны журмаар ҮБХИС-ийн багш, судлаач, суралцагч болон тэдний хамтран ажиллаж байгаа судалгааны дотоод, гадаадын байгууллагууд нь шинжлэх ухаан, үйлдвэрлэл, техник технологийн хөгжил, хүний сайн сайхны төлөө гүйцэтгэгдэж байгаа аливаа судалгаа, ажиглалт, сорилт, туршилт, шинжилгээний үед судалгааны ёс зүйн нийтлэг үнэт зүйлс, ёс суртахууны зарчим, хэм хэмжээг мөрдлөг болгохыг зохицуулна.
- 1.3. Тус журам нь ҮБХИС-ийн дүрэм, ҮБХИС-ийн ёс зүйн дүрэм, Оюуны өмчийн талаар баримтлах бодлогыг баримтлана.
- 1.4. ҮБХИС-ийн хэмжээнд, их сургуулийн нийт гишүүдийн хийж гүйцэтгэх аливаа судалгаа, туршилт, ажиглалт, шинжилгээний үед баримтлах судалгааны ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, судалгаанд оролцож буй субъектүүдийн аюулгүй байдлыг хамгаалах, судлаачдыг эрх зүйн талаарх аливаа асуудлаас хамгаалах үүрэгтэй.
- 1.5. Судалгааны ажлын ёс зүйг баримтлах олон улсын зөвлөмж, эрх зүйн зохицуулалт, Монгол Улсад хэрэгжиж буй холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, ҮБХИС-д хэрэгжиж буй эсхүл ҮБХИС-ийн багш, судлаачид, оюутнуудын оролцож буй судалгааны ажлын ёс зүйн асуудлыг шийдвэрлэнэ.

**2. СУДАЛГААНЫ ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН ХОРООНЫ БҮТЭЦ,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, БҮРЭЛДЭХҮҮН**

- 2.1. Хороог мэргэжлийн багш, судлаачийн төлөөллийг оролцуулсан, хүйсийн тэгш байдлыг харгалзсан 11 гишүүдтэйгээр бүрдүүлж, ҮБХИС-ийн захирлын тушаалаар байгуулна.
- 2.2. Хороо нь дарга, нарийн бичгийн дарга, санал өгөх эрхтэй гишүүдээс бүрдэнэ.
- 2.3. Хорооны гишүүдийн гуч хүртэл хувийг 2 жил тутамд шинэчлэн батална.
- 2.4. Хороо нь ҮБХИС-ийн <http://www.mndu.gov.mn/> сайтад танилцуулга хуудастай байна.
- 2.5. Хороо нь албан маягттай, албан Е-мэйл хаягтай байна.

**3. СУДАЛГААНЫ ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН
ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 3.1. ҮБХИС-д хэрэгжиж байгаа эрдэм шинжилгээ, судалгааны ажлын арга аргачлалын ёс зүйн асуудлыг хэлэлцэж, судалгаа хийх ёс зүйн зөвшөөрөл олгоно.
- 3.2. Хамтын ажиллагаатай гадаадын их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, олон улсын байгууллагын хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд судалгааны ёс зүйн зөвшөөрөл олгоно.
- 3.3. ҮБХИС-д болон хамтын ажиллагаатай гадаадын их сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, олон улсын байгууллагад хэрэгжүүлсэн эрдэм

- шинжилгээ, судалгааны ажлын гүйцэтгэлийн ёс зүйн асуудлыг хэлэлцэж дүгнэлт гаргана.
- 3.4. Судалгааны ажлын ёс зүйн чиглэлээр сургалт зохион байгуулж, ёс зүйн зөвлөгөө өгнө.
 - 3.5. Судалгааны ёс зүйн хяналтын хороонд материал хүлээн авах, шийдвэрлэх.
 - 3.6. Зөвшөөрөл олгох. Бичиг баримтыг сар бүрийн гуравдах долоо хоногийн Мягмар гарагийн 17.00 цаг хүртэл цахим (<http://www.mndu.gov.mn/>) хуудсаар бүртгэн хүлээн авна.
 - 3.7. Дүгнэлт гаргах. Бичиг баримтыг сар бүрийн гуравдах долоо хоногийн Мягмар гарагийн 17.00 цаг хүртэл цахимаар (<http://www.mndu.gov.mn/>) хуудсаар бүртгэн хүлээн авна.
 - 3.8. Бүрдүүлсэн материал шаардлага хангаагүй тохиолдолд хэлэлцүүлгийг хойшлуулна.
 - 3.9. Дүгнэлт гаргасан гишүүн СЕЗХХ-ны хурал дээр дүгнэлтээ гишүүдэд танилцуулан хэлэлцүүлнэ.
 - 3.10. Хурлын тогтоол. Хэлэлцэгдсэн ажлуудад дугаар бүхий зөвшөөрөл ба дүгнэлт олгож хурлын шийдвэрийг хурал болсноос хойш 7 хоногийн дараа цахим (<http://www.mndu.gov.mn/>) хуудсанд байршуулна.
 - 3.11. СЕЗХХ нь тухайн хорооны үйл ажиллагаатай холбоотой санал, гомдлыг нарийн бичгийн дарга (<http://www.mndu.gov.mn/>) цахим хуудсанд буй хаягаар цахимаар болон цаасан хэлбэрээр хүлээн авч 1 сарын дотор хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, СЕЗХХ-ны хурал дээр дарга танилцуулна.

4. СУДАЛГААНЫ ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН ХОРООНЫ ДАРГА, НАРИЙН БИЧГИЙН ДАРГА, ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ, ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

- 4.1. Даргын эрх, үүрэг:
 - 4.1.1. Хурлыг удирдах;
 - 4.1.2. Ээлжит бус хурлыг зарлах;
 - 4.1.3. Хэлэлцэх материалын ёс зүйн эрсдэлийн түвшнийг тодорхойлох;
 - 4.1.4. Дүгнэлт гаргах шинжээч гишүүнийг томилох;
 - 4.1.5. Хурлын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих.
 - 4.1.6. СЕЗХХ-ны гишүүдийг үүргээ биелүүлээгүй, ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн тохиолдолд чөлөөлөх саналыг ҮБХИС-ийн захиралд хүргэх.
 - 4.1.7. СЕЗХХ-ны хурлын тогтоолд гарын үсэг зурж баталгаажуулах.
- 4.2. СЕЗХХ-ны нарийн бичгийн даргын эрх, үүрэг:
 - 4.2.1. Дүгнэлт гаргах шинжээч гишүүнийг даргад санал болгон танилцуулах;
 - 4.2.2. СЕЗХХ-ны хурлын бэлтгэлийг хангаж ёс зүйн зөвшөөрөл авах болон дүгнэлт гаргах материалыг нийт гишүүдэд хурал эхлэхээс 3-аас доошгүй хоногийн өмнө цахим хэлбэрээр хүргүүлэх;
 - 4.2.3. СЕЗХХ-ны хурлын шийдвэрийн дагуу тогтоолыг ҮБХИС-ийн <http://mnums.edu.mn> сайтад байршуулах;
 - 4.2.4. СЕЗХХ-ны тогтоолын хувийг архивлан хадгалах;.
- 4.3. СЕЗХХ-ны гишүүний эрх, үүрэг:
 - 4.3.1. Хорооны үйл ажиллагааны талаар болон хэлэлцэж буй асуудлын талаар хуралд санал хэлэх;
 - 4.3.2. Судлаачдын судалгааны ажлыг эхлүүлэх зөвшөөрөл олгох, хянах, ёс зүйн шаардлага хангаагүй судалгааны ажлыг түдгэлзүүлэх, зогсоох, дүгнэлт гаргах санал оруулан шийдвэрлүүлэх;
 - 4.3.3. ҮБХИС-д хэрэгжиж байгаа эрдэм шинжилгээ, судалгааны ажил, төсөл, хөтөлбөртэй танилцаж хуралд санал оруулах;
 - 4.3.4. Шаардлагатай тохиолдолд судлаач, судалгааны багаас нэмэлт мэдээлэл авах;

- 4.3.5 Хорооны гишүүнээс татгалзах;
- 4.3.6 ҮБХИС дээр хэрэгжиж буй багш, судлаачдын судалгааны ажилд ёс зүйн холбогдолтой алдаа, дутагдал гарахаас сэргийлэх зөвлөмж өгөх;
- 4.3.7 Хүнтэй холбоотой бүхий л эрдэм шинжилгээ, судалгааны ажилд хувь хүнийг хүндэтгэх, эрхийг дээдлэх, үр ашигтай, хор хөнөөлгүй байх, тэгш хандах зарчмыг мөрдүүлэх;
- 4.3.8 Туршилтын амьтны амьдрах орчин аюулгүй байдлыг ханган, хүмүүнлэгийн зарчим баримтлан амьтныг зовоохгүй, тарчлаахгүйгээр судалгаа хийх, өгүүтгэх зарчмыг мөрдүүлэх;
- 4.3.9 Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх;
- 4.3.10 Хэлэлцэж буй асуудлаар ашиг сонирхолгүй гишүүн санал хураалтад оролцох;
- 4.3.11 Хуралд оролцох боломжгүй тухайгаа хурал болохоос нэг хоногийн өмнө дарга буюу нарийн бичгийн даргад мэдэгдэх;
- 4.3.12 Хорооны хурлын хамтын шийдвэрийг мөрдөх;
- 4.4 СЕЗХХ-ны гишүүдийн ёс зүйн хэм хэмжээ:
- 4.4.1 Хуулийг дээдэлж, олон улсын болон үндэсний хэмжээнд судалгааны ёс зүйн чиглэлээр гарсан баримт бичиг, журмыг мөрдлөг болгон, ёс зүйн алдаа гаргахгүй байх;
- 4.4.2 Бие даасан хараат бус байх;
- 4.4.3 СЕЗХХ-ны хурлын ирцийн гуравны нэгийг хүндэтгэх шалтгаангүйгээр тасалсан, гишүүний үүргийг биелүүлээгүй тохиолдолд СЕЗХХ-ны гишүүнээс чөлөөлөх саналыг ҮБХИС-ийн захиралд хүргэх.

5. СУДАЛГААНЫ ЁС ЗҮЙН ХЯНАЛТЫН ХОРООНЫ ХУРЛЫН ДЭГ

- 5.1 СЕЗХХ-ны хурлыг сар бүрийн гуравдугаар долоо хоногийн Баасан гарагт явуулна.
- 5.2 Шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурлыг дарга зарлан хуралдуулна.
- 5.3 СЕЗХХ-ны гишүүдийн 75 хувиас дээш ирцтэй тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцно.
- 5.4 СЕЗХХ-ны хурал нээлттэй болон цахим хэлбэрээр хуралдана.
- 5.5 Дарга хурлын эхэнд дэгийг танилцуулж батлуулсны дагуу удирдана.
- 5.6 Хуралд танилцуулга хийх, асуулт асууж, санал хэлэх зөвшөөрлийг дарга олгоно.
- 5.7 Хэлэлцэж буй асуудлын талаар гишүүдийн 75 хувиас дээш дэмжсэн тохиолдолд батална.

6. СЕЗХХ-НЫ САНХҮҮЖИЛТ

- 6.1. СЕЗХХ-ны үйл ажиллагаа, бичиг хэргийн болон холбогдох бусад зардлыг үй уйл ажиллагааны хураамжаар зохицуулна.
- 6.2. СЕЗХХ-ны хурлаар ёс зүйн асуудлаа шийдвэрлүүлэхэд 20000 төгрөгийн хураамж төлнө.
- 6.3. Хуралд оролцсон гишүүдэд олгох урамшуулал, шаардлагатай бичиг хэргийн болон холбогдох бусад зардлыг хураамжаас гаргана.
- 6.4. Хураамжийн зарцуулалтын тайланг нарийн бичгийн дарга жил тутам гаргана.

7. БУСАД

- 7.1. Судалгааны ёс зүйн зөвшөөрөл авахад бүрдүүлэх бичиг баримт.
- 7.1.1. Судлаачийн овог, нэр, хэлэлцүүлэх ажлын нэр, ямар нэгж, байгууллагаас оруулж байгааг тусгасан судалгаа хийх ёс зүйн зөвшөөрөл хүссэн өргөдөл;
- 7.1.2. Судалгааны ажлын товчийг 250 үгэнд багтаасан танилцуулга;

- 7.1.3. Судалгааны ажлын батлагдсан арга, аргачлал;
- 7.1.4. Хэрэв хүнийг хамруулсан судалгаа бол таниулсан зөвшөөрлийн хуудас;
- 7.1.5. Судалгааны арга, аргачлалыг хэлэлцсэн тухай тэнхим, бүрэлдэхүүн сургууль, эрдмийн зөвлөлийн хурлын хурлын тэмдэглэл, шийдвэр;
- 7.1.6. Гаднын байгууллагатай хамтарсан буюу санхүүжилт авч буй бол тухайн байгууллагын ёс зүйн хяналтын хорооны зөвшөөрлийн хуулбар, албан ёсны орчуулгын хамт. Үүнд хамтын ажиллагааны гэрээтэй гадаад улсын Их сургууль, байгууллагын ёс зүйн хяналтын хорооны албан бичиг;
- 7.1.7. Судалгаа хийх байгууллагын зөвшөөрөл бүхий албан бичиг тус тус хамаарна.